



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ДЭЭД ТҮВШНИЙ ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСЛЭЛ

Мянганы хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийн хугацаа 2015 онд дуусгавар болж, түүний залгамжлал болсон Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг дэлхийн хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын төрийн тэргүүнүүдийн саналын үндсэн дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы A/70/L.1 тоот шийдвэрээр тунхаглан баталсан.

Тус шийдвэрийн 75, 78, 79 дугаар заалтуудад улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг үндэсний түвшинд тодорхойлох, тэдгээрийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хэрэгжүүлж, хэрэгжилтийн үнэлгээг олон талын оролцоотойгоор тогтмол хийх тухай заасан байдаг. Улс орнууд эдгээр зорилгуудыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан үндэснийхээ онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд дэлхийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах, хөгжлийн тогтолцоог шинэ шатанд хүргэх түүхэн ач холбогдол бүхий Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сард тус тус баталсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга 2019 оны 9 дүгээр сард нийгмийн бүхий л бүлгүүдийг “Арван жилийн үйл ажиллагаа” (Decade of Action)-г дараах 3 түвшинд чиглүүлэхийг уриалсан. Үүнд:

1. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг манлайлал, нөөц бололцоо, ухаалаг шийдлээр хангах **Дэлхий нийтийн хүчин чармайлт, үйл ажиллагаа**;
2. Засгийн газар, хот, орон нутгийн засаг захиргааны бодлого, төсөв, институц болон хууль, эрх зүйн хүрээнд шаардлагатай шилжилтийг хийх **үндэсний хүчин чармайлт, үйл ажиллагаа**;
3. Хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, залуучууд, иргэний нийгэм, шинжлэх ухаан, хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад оролцогч талуудыг хамарсан шаардлагатай өөрчлөлтийн төлөөх **хүмүүсийн хүчин чармайлт, үйл ажиллагаа** багтана.

Бусад орнуудын адил, Монгол Улс 2030 он гэхэд Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг хангахад “Арван жилийн үйл ажиллагаа” (Decade of Action)-ны хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай. Ковид-19 цар тахлын нөхцөл байдал Тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд гарсан ахиц дэвшлийг сааруулж байгаа тул цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд бүх хүчин чармайлтаа сайжруулахын зэрэгцээ өнөөгийн ахиц дэвшлээ хадгалж үлдэх нь нэн чухал юм. Монгол Улсын хувьд, цар тахлын дараах сэргэлтийг ирээдүйн боломжит эрсдэлүүдийг бууруулахад чиглүүлэх болон “Арван жилийн үйл ажиллагаа” (Decade of Action)-ны явцад Тогтвортой хөгжлийн зорилгуудын биелэлтийг хангах алхмуудыг хийж эхлээд байна.

Улсын Их Хурлын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо нь Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх асуудлыг хариуцан ажилладаг. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Тогтвортой хөгжлийн зорилгын Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг салбарын яамд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага болон Нэгдсэн Үндэстний Байгууллага зэрэг төлөөллүүдийг хамруулан өргөжүүлж, шинэчлэн байгуулсан. Мөн институт болон бодлогын уялдааг хангах, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд шаардлагатай нөөц боломжийг чиглүүлэх Тогтвортой хөгжилд чиглэсэн олон талын оролцоо бүхий платформыг нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулсан.

Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д заасны дагуу Засгийн газар “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх үүрэгтэй бөгөөд Засгийн газраас олон талын оролцоог ханган энэхүү төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үндэсний онцлогт нийцүүлэн боловсруулсан Тогтвортой хөгжлийн зорилгыг баталж, хэрэгжүүлснээр 2030 он гэхэд эдийн засаг, нийгэм, байгаль орчинд ахиц дэвшил гарах, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хянах, үнэлэх, цар тахлын дараах үеийн нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих боломж бүрдэх юм. Түүнчлэн, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд олон талын хамтын ажиллагааг сайжруулах, түншлэлийг бэхжүүлэх арга замыг тодорхойлох нь нэн чухал байна.

ЗОРИЛГО

Чуулга уулзалтын зорилго нь цар тахлаас үүдсэн сөрөг нөлөөг даван туулах, эдийн засгийн сэргэлтийг хурдасгах болон 2030 он гэхэд хүрэх Тогтвортой хөгжлийн зорилгын “Арван жилийн үйл ажиллагаа” (Decade of Action)-ны хэрэгжилтийг эрчимжүүлэхэд олон талын оролцоог хангаж, санал солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Чуулга уулзалтаар Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд гарч буй ахиц дэвшил, тулгарч буй саад бэрхшээл болон Ковид-19 цар тахлын үед хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн олон улсын сайн туршлага, арга зам, шийдлийн талаар бодлого тодорхойлогчид, шийдвэр гаргагчдын түвшинд олон талын оролцоог ханган хэлэлцэнэ.

Түүнчлэн, чуулга уулзалтын үеэр Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хянах, түүнийг эрчимжүүлэхэд шаардлагатай бүхий л нөөц боломжийг чиглүүлэх үр дүнтэй зохицуулалтын механизм болох Тогтвортой хөгжилд чиглэсэн олон талын оролцоо бүхий платформыг танилцуулна.

ОРОЛЦОГЧИД

1. Улсын Их Хурлын гишүүд;
2. Төрийн байгууллагууд;
3. Иргэний нийгмийн байгууллагууд;
4. Хувийн хэвшлийн байгууллагууд;
5. Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагууд;
6. Олон улсын байгууллагууд;
7. Хэвлэл мэдээллийн байгууллагууд.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР

Чуулга уулзалт танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Холбоо барих:

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
С.Сюзанна /51-264926, suzanna.s@nda.gov.mn/

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Т.Мөнхцэцэг /51-261575, munkhtsetseg.teg@gmail.com/